



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монголын цахилгаан холбоо" хувьцаат компанийн 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийн төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатарыг томилсугай.

2. "Монголын цахилгаан холбоо" хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч В.Дарханбаатарт даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132003219

ТӨБЗГ тушаал-/2022

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны
өдрийн 4/37 дугаар тушаалын хавсралт



“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ТӨРИЙН
ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1.Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах;

2.Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэж батлах;

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;

4.Компанийн 2020 оны ногдол ашиг тараасан тухай тайлан болон 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган шийдвэрлэх, тогтоолыг танилцуулах.

5.Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн болон хараат бус гишүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгох;

6.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган батлах;

7.Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд санал өгч оролцох.

-----oO-----

САНГИЙН ЯАМ,